# ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ЛХАГВАСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхлэх, дуусах хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилго 1. “Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.”** | | | | | | | |
| **Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.** | | | | | | | |
| 1. | “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалт боловсруулах | Шинэчлэн боловсруулсан жагсаалтын төсөл | ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоол | | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны А/102 тушаалыг шинэчлэн боловсруулж, 2024 оны А/157 дугаартай тушаалыг батлуулсан. Тогтоолын төслийг ЭМЯ, СЯ-нд хүргүүлж саналыг авсан. Саналыг судалж, тусгасан, 2024 оны эцэст ЭМДҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. | 2024.01.01 – 2024.12.04 | 90% |
| 2. | Төлбөрийг нь төр хариуцах өвчин эмгэгийг эмчлэх эмийн нэр төрлийг тодорхойлсон жагсаалт боловсруулах | Шинэчлэн боловсруулсан жагсаалтын төсөл | ЭМДҮЗ-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолын 4, 5 дугаар хавсралт | | Тус жагсаалтыг ЭМС-ын 2022 оын А/407 дугаар тушаалд заасны дагуу олон улсын эмнэлзүйн удирдамж, Up-To-Date-ээс тус тушаалын хавсралтаар баталсан өвчний үед хэрэглэх эмүүдийг түүн тодорхойлсон. Мөн Захиргааны ерөнхий хууль, ЭМД тухай хуульд заасны дагуу ЭМЯ, Сангийн яам, холбогдох ЭМБ-уудаас санал авч тусган удирдлагад хүргүүлсэн. Тус жагсаалтын төслийг ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан. Тус жагсаалтыг шинэчлэн боловсруулж ЭМДҮЗ-ийн 2024 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад байх төслийг боловсруулж ЭМДҮЗ-өөр батлуулсан. | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |
| 3. | Төлбөрийг нь төр хариуцах өвчин эмгэгийг эмчлэх эмийг олгох, | Шинэчлэн боловсруулсан журмын төсөл | ЭМДҮЗ-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолын 4, 5 | | Тус журмын төслийг боловсруулан Захиргааны ерөнхий хууль, ЭМД тухай хуульд заасны дагуу олон нийт, ЭМБ-ууд, ЭМЯ, Сангийн яамнаас санал авч тусган удирдлагад хүргүүлсэн. Тус журмын төслийг ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | санхүүжүүлэх журмыг боловсруулах | | дугаар хавсралт | дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан ба одоогоор хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Тус журмыг шинэчлэн боловсруулж ЭМДҮЗ-ийн 2024 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад байх төслийг боловсруулж ЭМДҮЗ-өөр батлуулсан. | | |
| 4. | Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх тогтоол, төлбөрийг нь төр хариуцах эмийн журмын хэрэгжилтэд үнэлгээ хийх | Боловсруулсан саналын төсөл | ЭМДЕГ-ын даргын 2020 оны А/115 дугаар тушаал , ЭМДҮЗ-ийн 2021 оны 01 дүгээр тогтоол | Тус журмын хүрээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор ЭМД-ын төв, орон нутгийн хэлтсүүд, ЭМЯ, СЯ-аас болон олон нийтээс санал авч, 2 удаа шинэчлэн боловсруулж ЭМДҮЗ-ийн 2024 оны 06, 2024 оны 14 дүгээр тогтоолоор тус тус батлуулсан. Хөнгөлөлттэй эмийн журмын төслийг шинэчлэн боловсруулж ЭМДҮЗ-өөр хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |
| 5. | Эрүүл мэндийн даатгалын байгууллагын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, ЭМДС-ийн статистик мэдээллийг эмхэтгэлд шаардлагатай мэдээллийг боловсруулан хүргүүлэх | Боловсруулсан хүснэгт бүхий мэдээллийн тоо | Өмнөх оны статистик эмхэтгэлийн ном боловсруулагд аагүй | Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх тусламж, үйлчилгээний хүрээнд эм, даатгуулагчийн ангилал болон хөнгөлөлтийн хувийн ангиллаар тоон мэдээллийг боловсруулан, батлагдсан загварын дагуу гаргаж ажлын хэсгийн холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.<br>Төлбөрийг нь төр хариуцах эмийн тусламж, үйлчилгээний хүрээнд өвчний ангиллаар нь ялгасан санхүүжилтийн тоон мэдээллийг 21 аймаг, 9 дүүргээс авч, нэгтгэн, тоон мэдээллийг боловсруулж, батлагдсан загварын дагуу гарган ажлын хэсгийн холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |
| **Зорилт 1.3. Цахим шилжилтэд бүрэн шилжинэ.** | | | | | | |
| 6. | Эрүүл мэндийн даатгалын цахим системд төр хариуцах эмийн шинэ хөгжүүлэлт хийх | Шинээр боловсруулсан бодлогын даалгавар, процессын зураглал | Өмнө нь цахим хөгжүүлэлт хийгдэж байгаагүй | Эрүүл мэндийн даатгалын цахим системд шинэчилсэн тогтоолын үндсэн бодлогын даалгаврыг хамтран боловсруулж, дотоод албан бичгээр хүргүүлсэн. Төр хариуцах эмийн цахим системийг эрүүл мэднийн байгууллагуудад тестлэх ажлыг хийсэн бөгөөд 2024 оны 10 сарын 14-ний өдөр холбогдох эрүүл мэндийн байгууллагын албан тушаалтнуудад эрүүл мэндийн даатгалын цахим систем болон төр хариуцах эмийн цахим системийн хөгжүүлэлттэй холбоотой асуудлаар уулзалт хэлэлцүүлэг хийсэн. Төр хариуцах эмийг олгож байгаа эрүүл мэднийн байгууллагын хөгжүүлэгч И-хеалт програм ашигладаг Хавдар судалын үндсэний төв, Карте програм ашигладаг Бриллиант эмнэлгийн цахим системыг газар дээр нь очиж танилцан, мэдээлэл өгч | 2024.01.01 – 2024.12.04 | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | зарим холбогдох өөрчлөлтийг тухайн хөгжүүлэгч байгууллагад танилцуулж шийдвэрлүүлсэн. | | |
| 7. | Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох тогтоолын хүрээнд бодлогын даалгавар боловсруулах | Шинээр боловсруулсан бодлогын даалгавар, процессын зураглал | Одоогийн жорын цахим системд хөгжүүлэлт хийсэн бодлогын даалгавар | Тус тогтоолын төсөлд шинээр тусгагдсан үндсэн 5 төрлийн өөрчлөлтийг цахим системд хөгжүүлэх боломжтой эсэх, боломжтой бол хэрхэн хийх талаар МТХ-тэй уулзалт зохион байгуулсан ба тогтоолын төслийг ЭМДҮЗ-өөс баталсан тохиолдолд бодлогын даалгавар болон зураглалыг МТХ-д албан байдлаар хүргүүлэх, хамтран ажиллахаар төлөвлөж байна. | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |
| **Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна.** | | | | | | |
| **Зорилт 3.2.Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна.** | | | | | | |
| 8. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цахим хяналтын шүүлтүүр ажиллаж буй эсэхэд хяналт хийж, сайжруулалтын арга хэмжээ авч ажиллана. | Цахим хяналтын шүүлтүүрийг сайжруулахаар боловсруулсан саналын төсөл | Одоогийн жорын цахим системд хөгжүүлэлт хийсэн бодлогын даалгавар | Цахим хөгжлийн яам, Гааль, татвар санхүүгийн мэдээллийн технологийн төвөөс эмийн сангийн ПОС ЭЙ ПИ АЙ 3.0 системийг хөнгөлөлттэй эмийн борлуулалтын хэсэгт шинэчлэн оруулсантай холбоотой зарим эмийн баркод солигдсон тул тухайн мэдээллийн хөнгөлөлттэй эмийн баазад шинэчилсэн, мөн цахим хяналтын шүүлтүүрийн хэвийн ажиллагаатай байгаа эсэхэд тогтмол хяналтыг тавьж ажиллаж байна. ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хүрээнд 6,798,429,222 төгрөгийг цахим шүүлтүүрээр хасч эрүүл мэндийн даатгалын санг хамгаалсан байна. | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |
| **Зорилго 4. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | |
| **Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжине.** | | | | | | |
| 9. | Төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, сургалт хийнэ. | Сургалтын тоо | 2 | Төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэст ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хорт хавдрын дараах химийн бай эмчилгээний тусламж, үйлчилгээний талаар 5 удаагийн дотоод албан бичгээр, 3 удаагийн Zoom сургалтаар чиглэл хүргүүлсэн , ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын шинэчилсэн төслийн талаар 1 удаагийн цахим сургалт хийсэн. | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |
| 10. | Гэрээтэй ЭМБ-дад сургалт зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар | Сургалтын тоо | 7 | Гэрээт ЭМБ-уудад Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд эмийн жор бичилт, хүртээмжийг сайжруулах талаар чиглэл хүргүүлсэн 1 удаагийн цахим зар, 2 удаагийн албан бичгээр чиглэл | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хангах үйл ажиллагааг зохион байгуулна. | | | хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Төлбөрийг нь төр хариуцах эмийн цахимжилттай холбоотой ЭМБ, цахим систем хөгжүүлэгчид, ЭМДХ-үүдэд 5 удаагийн сургалтыг зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангасан байна. Нийт 8 удаагийн сургалт зохион байгуулсан байна. | | |
| 11. | Иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сурталчлан таниулах арга хэмжээг бусад газар, хэлтэстэй хамтран хэрэгжүүлнэ. | Арга хэмжээний тоо | 5 | -ОНХХ-д Хорт хавдрын бай эмчилгээний сэдэв бүхий 1 бичлэг бэлтгэн хүргүүлж, олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан мэдээллийг хүргэсэн.<br>- Хорт хавдрын тусламж, үйлчилгээний хүрээнд "Наран ижий заяа ТББ", ЭЭХХЗГ, ХСҮТ, Бриллиант, Рехамед, СХНЭ-үүдийг хамруулсан 1 удаагийн танхимын хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>-Хөнгөлөлттэй эмийн тогтоолын хүрээнд 4 удаагийн уулзалт зохион байгуулсан.<br>-Төлбөрийг нь төр хариуцах эмийн хүрээнд 5 удаагийн уулзалт зохион байгуулсан. Нийт 11 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 2024.01.01<br>–<br>2024.12.04 | 100% |
| 12. | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврын дагуу хэрэгжүүлнэ. | Албан бичгийн тоо, шийдвэрлэлтийн хувь | 84 албан бичиг, 100% | 1. Албан бичиг /гадаад/: Ирсэн-180, Явсан 180, шийдвэрлэлт 100%<br><br>**Гадагшаа явуулсан бичгийн агуулга — Тоо**<br>Баримт хүргүүлэх тухай — 4<br>Бэлэн байдлыг хангуулах тухай — 1<br>Гэрээ шинэчлэх хүсэлтийг хүргүүлэх тухай — 1<br>Итгэмжлэл олгох тухай — 3<br>Мэдээлэл хүсэх тухай — 101<br>Санал авах тухай — 7<br>Санал хүргүүлэх тухай — 3<br>Сургалтад урих тухай — 1<br>Тодруулга хүсэх тухай — 2<br>Хамтран ажиллах санал хүргүүлэх тухай — 1<br>Хариу хүргүүлэх тухай — 52<br>Хэлэлцүүлэгт урих тухай — 3<br>Чиглэл хүргүүлэх тухай — 1<br>**НИЙТ** — 180<br><br>2. Албан бичиг /дотоод/: Явсан – 57<br><br>**Дотоод явуулсан бичиг хүргүүлсэн газар, хэлтэс — Тоо** | 2024.01.01<br>–<br>2024.12.04 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | МТХ-д 40<br>ОНХХ-д 1<br>ОНЭМДХ-д 2<br>СБХ-д 2<br>ТГ-д 5<br>ТҮЧТХГ-д 1<br>ХАГГ-д 6<br>**нийт 57** | | |
| 13. | Газрын даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хэрэгжүүлсэн ажлын тоо | 4 | **Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад оруулсан эмийн нэр төрөл, түүний шалгуур, жагсаалтыг холбогдох аргачлалын дагуу боловсруулж дараах гол гол өөрчлөлтийг хийж ажиллалаа. Үүнд:**<br>1. Өвчинд суурилсан аргачлалын дагуу оношийг өргөжүүлсэн<br>2. Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалттай нийцүүлэн шалгуурын дагуу боловсруулсан<br>3. ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлагдсан эм сонгох аргачлалын дагуу худалдааны нэршлийн эмийн жагсаалтыг өргөжүүлсэн<br>Эмийн үнийн дээд хязгаарыг тодорхойлохдоо ЭМДЕГ-ын даргын 2020 оны А/102 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу тогтоосон. Үнийн дээд хязгаарын шинэчлэн тооцоолохдоо Татварын ерөнхий газрын нэмэгдсэн өртгийн албан татварын баримтын мэдээний сан /ибаримт/, Гаалийн ерөнхий газрын гаалийн үнийн мэдээлэл, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын импортын үнийн мэдээлэл, эмийн мэргэжлийн холбоодоос ирүүлсэн үнийн мэдээлэл, эм ханган нийлүүлэх байгууллагуудаас албан бичгээр ирүүлсэн үнийн мэдээлэл, эмийн сангийн сангийн жижиглэнгийн үнийн мэдээлэл болон ЭМДҮЗ-ийн 11 дүгээр тогтоолын үнийн мэдээллийг тус тус харгалзан үзсэн болно. ЭМДҮЗ-ийн 11 дүгээр тогтоолоос шинэчилсэн жагсаалтад багтсан 440 эмийн шинэчилсэн үнийг дэлгэрэнгүй авч үзвэл нэгж үнийн дүн нь дунджаар | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 171 төгрөгөөр буюу 1826-аас 1997 болж 9.4 хувиар нэмэгдсэн. Үүнээс үнийн хувьд өөрчлөлтгүй 27 эм, 374 эмийн үнэ 4-14129 төгрөгийн хооронд буюу дунджаар 236 төгрөгөөр өссөн, 39 эмийн үнэ 1-5510 төгрөг буюу дунджаар 336 төгрөгөөр буурсан байна.<br><br>**Эмийн үнийн хөнгөлөлт олгох журам, хяналтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр:**<br>1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд заасан нэг эх үүсвэрийн худалдан авалт, эмийн үнийг тогтоох, үнэ бууруулах хэлэлцээр хийх зохицуулалт, үйл явцыг нарийвчлан журамласан<br>2. Хөнгөлөлттэй эмийн цахим жорын баталгаажилтыг техник, технологийн дэвшилтэй уялдуулсан даатгуулагчдад хялбар, альваа ашиглан болон бусад төрлийн хууль бус нэхэмжлэлээс сэргийлэх аргууд<br>3. Жорын нэхэмжлэлийг 2-3 үе шаттайгаар буюу цахим, нарийвчилсан, газар дээрх хяналт хэрэгжүүлж зөрчлөөс сэргийлэх<br>4. Жорын сэжигтэй тохиолдлыг илрүүлж, тухайн нөхцөлд эмч, эрүүл мэндийн байгууллагад сануулга өгөх цахим хөгжүүлэлтийн зохицуулалт, хариуцлага тооцох зохицуулалт<br>5. Эмийн зохисгүй хэрэглээг бууруулах, жор бичих эмийн харилцан үйлчлэлийн цахим системийн хөгжүүлэлт<br>6. Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах, алслагдсан бүс нутагт эмийн нөөцийг бүрдүүлэхэд хөшүүрэг болгох зорилгоор бүсийн коеффицентээр санхүүжүүлэх зохицуулалт<br><br>**"Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтын нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хувийг тогтоох аргачлал"-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан.** | | |
| 14. | ЭМДҮЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, ЭМДҮЗ-ийн | Боловсруулсан тайлан | Өмнөх оны үнэлгээний тайлан | ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хэрэгжилтийн тайланг боловсрулан холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. Үүнд: | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажлын албанд хүргүүлж ажиллана. | | | 1. Эмийн үнийн хөнгөлөлт олгох жагсаалтаар 156 өвчний үед хэрэглэх 161 эмэнд хамаарах 651 худалдааны нэршлийн эмийг 30, 50, 70, 100 хувийн хөнгөлөлт үзүүлж байна. Үүнээс 0-19 хүртэлх насны хүүхдэд уналт, таталт өвчнийг эмчлэх 15 ерөнхий нэршлийн 77 болон "Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр"-ийн 15 ерөнхий нэршлийн 26 эмүүдэд эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувийн хөнгөлөлт олгосон байна.<br>2. Тус тогтоолын хүрээнд уналт, таталтын эсрэг эмийг 0-19 хүртэлх насны нийт 4156 хүүхдэд 2.2 тэрбум төгрөгийн үнийн хөнгөлөлтийг үзүүлсэн байна. Новартис хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд нийт 285,172 даатгуулагчид 4.4 тэрбум төгрөгийн үнийн хөнгөлөлтийг үзүүлсэн байна.<br>3. Эмийн үнийн хөнгөлөлт олгох 2023 оны байдлаар давхардаагүй тоогоор нийт 645,852 мянган даатгуулагч авсан буюу Монгол Улсын нийт хүн амын 18 хувьд нь хүрч байна. Тухайн тусламж, үйлчилгээг авч байгаа даатгуулагчдын хувьд 2020 онтой харьцуулахад 58.8 хувиар өссөн нь хүртээмж нэмэгдэж байгааг харуулж байна.<br>4. Мөн хөнгөлөлттэй эм авч байгаа нийт даатгуулагчийн 51 хувийг тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй даатгуулагч буюу 2 даатгуулагч тутмын 1 нь өндөр настан байна.<br>5. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт авч байгаа даатгуулагчид дундажаар худалдан авч буй эмийнхээ 37-46 хувийг халааснаасаа төлж байна. Мөн олон эрхтэн системийн эмгэгтэй 352 мянган даатгуулагч байгаагаас 67 хувь нь тэтгэврээс өөр орлогогүй иргэд байна. Тухайн тэтгэврийн иргэдийн 0.2 хувь жилийн дундаж тэтгэврийн орлогын 36 хувийг хөнгөлөлттэй эм авахдаа халааснаасаа төлж байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4.2. Дотоод зохион байгууллалтын ажилд оролцох, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 15. | Байгууллагын үйл ажиллагаа, даатгуулагчийн эрх болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийн талаарх олон нийтэд хүргэх мэдээллийн агуулгыг бэлтгэж, холбогдох нэгжид хүргүүлэн ажиллана. | Хүргүүлсэн мэдээллийн тоо | 5 | Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох тусламж, үйлчилгээ, төлбөрийг нь төр хариуцах эмийн тусламж, үйлчилгээний хүрээнд олон нийтийн цахим сүлжээ, лавлах утас, ЗГ-ын 11-11-ээр тогтмол ирдэг асуултад холбогдох хариултыг бэлтгэн хүргүүлсэн. | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |
| 16. | Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 лавлах утсаар дамжиж хандсан, 7010-1125 утсанд ирсэн дуудлаганд даатгуулагч-иргэдийн эрүүл мэндийн даатгалын талаарх төрийн үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө, мэдээлэл хүргэж, санал гомдлыг шийдвэрлэнэ. | Гомдол, дуудлагын тоо, шийдвэрлэлтийн хувь | 290 дуудлага, Able-ээр 2 гомдол, 100% | Албаны утсаар нийт 220 удаа ярьж зөвлөгөө, мэдээлэл өгч, санал гомдлыг шийдвэрлэсэн, 1800-1363 төвөөр дамжин ирсэн 8 өргөдлийг 100 хувьтай шийдвэрлэсэн.Үүнд:<br>• Хөнгөлөлттэй эм олгож буй эмийн сангийн талаар<br>• Хөнгөлөлттэй эмийн жагсаалтын талаар<br>• Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн талаар<br>• Гадаадын иргэн хөнгөлөлттэй эм авах талаар<br>• Төлбөрийг нь төр хариуцах эмийн талаар | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |
| 17. | Засгийн Газрын "Иргэд, олон нийттэй харилцах-1111" төвөөс ирсэн санал, гомдлыг шуурхай шийдвэрлэнэ. | Гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | 45 гомдол, 100% | Засгийн газрын 11-11 төвийн 33 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Үүнд:<br>• Хөнгөлөлттэй эм олгож буй эмийн сангийн талаар<br>• Хөнгөлөлттэй эмийн жагсаалтын талаар<br>• Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн талаар<br>• Гадаадын иргэн хөнгөлөлттэй эм авах талаар<br>• Төлбөрийг нь төр хариуцах эмийн талаар | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |
| 18. | Газрын дарга болон нэгжийн даргын өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хангана | Биелэлтийг хангасан үүрэг даалгаврын тоо | 8 | 1. Төлбөрийг нь төр хариуцах эмийн нэхэмжлэлийг нийслэлийн 13 байгууллагаас хүлээн авч, зарим эмийн нэхэмжлэлийг хянаж СБХ-д дотоод албан бичгээр хүргүүлсэн.<br>2. E-Daatgal аппликейшны хөгжүүлэлтэд шаардлагатай бодлогын даалгавар, | 2024.01.01 – 2024.12.04 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | шаардлагатай мэдээллийг боловсруулан МТХ-ийн холбогдох ахлах мэргэжилтэнд хүргүүлсэн.<br>3. Уналт, таталттай хүүхдийн нэрсийг тухай бүрд нь МТХ-д хүргүүлсэн.<br>4. Эмийн нэг эх үүсвэрийн худалдан авалтын ажлын хүрээнд ЭЭХХЗГ-тай хамтран ажиллаж 3 удаагийн албан бичгээр мэдээлэл хүргүүлсэн. Эмийн сангийн менежерүүдэд хийх сургалтын хүрээнд ЭЭХХЗГ-тай хамтран ажилласан<br>5. Хөнгөлөлттэй эмийн хамтын төлбөрийн дүн шинжилгээ болон холбогдох бусад тоон мэдээлэлд дүн шинжилгээг хийсэн.<br>6. Эмийн харицан үйлчлэлийн баазыг боловсруулахад АХБ-ны зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, шаардлагатай мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн<br>7. Дэлхийн банкны зөвлөх Сара-аас хөнгөлөлттэй эмийн талаар зөвлөгөө авах материалыг Монгол хэл дээр боловсруулж, Англи хэлрүү орчуулан АХБ-ны зөвлөхүүдтэй хамтран вебинарт бусад мэргэжилтнүүдийн хамтаар оролцсон.<br>8. ДЭМБ-ын үнэлгээний багт хөнгөлөлттэй эмийн талаар шаардлагатай тоон мэдээллийг бэлтгэн 7 төрлийг хүснэгтийг боловсруулж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.<br>9. Хорт хавдрын бай эмийн нэхэмжлэлийг хүлээн авч, хянасан.<br>10. Процессын дахин инженерчлэлийн хүрээнд шаардлагатай мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн. | | |

| | | |
|---|---|---|
| | | **НЭМЭЛТ АЖИЛ** |
| 19. | Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос зохион байгуулсан "Эмийн сонсгол"-ын хүрээнд хийсэн ажил | УИХ-ын хянан шалгах түр хороонд ЭМДҮЗ-ийн 2018 оны 24, 2020 оны 13, 2022 оны 11 дүгээр тогтоолын талаар 7 удаагийн албан бичгээр 900 гаруй хуудас мэдээллийг бэлтгэн мэдээлэл бүрийг цаг хугацаанд нь хүргүүлсэн. Тус сонсголтой холбоотойгоор ЭМЯ-д байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд мөн тус материалыг давхар бэлтгэн хүргүүлсэн. |
| 20. | "Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд хийсэн ажил | Новартис хөтөлбөрийн ажлын хэсгийн хүрээнд хөтөлбөрийн орлого, зарлага, борлуулалт, хүчинтэй хугацаа, серь дугаар, гаалийн мэдүүлгийн хугацаа, үнэ болон холбогдох бусад мэдээллийг агуулсан датабаазыг үүсгэн ажлын хэсгийн ахлагчид хүргүүлсэн. Гэрээ хийн ажилладаг дистрибьютерүүдтэй 3 удаагийн уулзалт хийж, чиглэл хүргүүлсэн 04/1107 |

| | | |
|---|---|---|
| | | дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэхээр ЭМДҮЗ-ийн хурлаар тогтоолын төслийг хэлэлцүүлсэн. |
| 21. | "Нэг эх үүсвэрээс эм худалдан авах" ажлын хүрээнд хийсэн ажил | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, ЗГ-ын тогтоолын дагуу нэг эх үүсвэрээс хөнгөлөлттэй эмийн жагсаалтад байх эм болон төлбөрийг нь төр хариуцах эмийг худалдан авах ажлын хүрээнд Эрүүл мэндийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу тухайн эмүүдийн худалдан авах боломжтой нэр төрөл, тоо хэмжээ, төсвийн нөлөө, ЭМДС болон иргэний төлөх дүнгийн тооцооллыг хийж ЭМЯ-д хүргүүлсэн. |
| 22. | Цахим жорын ажлын хэсэгт ажилласан тухай | Монгол Улсын хэмжээнд бүх эмийн жорыг цахимаар бичдэг болох зорилгоор байгуулсан ажлын хэсэгт ажиллаж, холбогдох эрүүл мэндийн сайдын тушаалын төсөлд албан бичгээр санал өгсөн. Ажлын хэсгийн хуралд 3 удаа оролцож санал өгсөн. |
| 23. | Жорын стандартын ажлын хэсэгт ажилласан тухай | Монгол Улсын жорын холбогдох стандартын шинэчилсэн төсөлд албан бичгээр санал өгсөн, ажлын хэсгийн хуралд 2 удаа оролцсон. |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 19. | Гадны ижил төстэй байгууллагууд болон олон улсын байгууллагуудын эрүүл мэндийн даатгалын системд холбогдох төсөл хөтөлбөр, уулзалт, хурал, мэдээлэлд оролцох | Оролцсон төсөл хөтөлбөр, уулзалт, хурлын тоо | 3 | Дэлхийн банкны зөвлөхийн вебинарт 2 удаа, бусад шаардлагатай уулзалт, хэлэлцүүлэг, хуралд тухай бүрт нь хамрагдсан. | | 2024.01.01 | 2024.12.04 |

**ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:**

ТҮБЗХ-ийн мэргэжилтэн ................................ / Г.Лхагвасүрэн / ......... ......... .........

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

БТГ-ын дарга ................................ / Б.Батчимэг / ......... ......... .........

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*